


ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

*Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчдээс
АН-ын 5 нэр дэвшигч, ХҮН-ын 2 нэр дэвшигч
сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.*



**ТӨВ АЙМГИЙН ИТХ- ЫН 2016 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НЭР
ДЭВШИГЧДИЙН СОНГУУЛИЙН
ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

2016 ОН

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар 3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 4
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Бүлэг 1 <i>Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчид нь 418329.0 мянган төгрөгийг сонгуулийн зардалд зарцуулжээ. 5-11</i>
Аудитын менежер О.Амаржаргал	
Ахлах аудитор Ц.Базарсад Т.Майцэцэг	Бүлэг 2 <i>Аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдэд иргэн хуулийн этгээдээс нийт 262015.0 мянган төгрөгийн хандив төвлөрсөнөөс сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасны дагуу нийтэд мэдээлэх 162455.0 мянган төгрөгийн хандив байна 12-14</i>
2016 оны 10 дугаар сарын 12-ны өдөр	
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	Дүгнэлт 15 Хавсралт судалгаа 16-20
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар 70272582, 70273204 дугаарын утас, 70272248 дугаарын факсаар харилцана уу	
ХАЯГ: Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	



Товчилсон үгийн тайлбар

МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
МАН	Монгол ардын нам
АН	Ардчилсан нам
МАХН	Монгол ардын хувьсгалт нам
ХҮН	Хөдөлмөрийн үндэсний нам
СТХ	Сонгуулийн тухай хууль
СТБ	Сонгуулийн төв байгууллага
ТАХ	Төрийн аудитын тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
УИХ	Улсын их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийсэн үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгийн хорооны 2016 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт , хамарсан хүрээ

Аймгийн ИТХ-ыг сонгох 2016 оны ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчийн авсан хандив, санхүүжилт болон зардлын тайланг хянан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлнэ.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Зардлын дүнг хянан нийтэд мэдээлэх,
- Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлах.

Аудитад аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны тайлан, хандивын тайлан холбогдох бусад материалууд хамрагдсан болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа

Аудитад Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

Төрийн аудитын тухай хууль

Төсвийн тухай хууль

НББ-ийн тухай хууль

Сонгуулийн тухай хууль

Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан холбогдох бусад хууль, тогтоомжууд

Аудитыг Төв аймгийн Аудитын газрын менежер О.Амаржаргал удирдан, ахлах аудитор Т.Майцэцэг, Ц.Базарсад нар 2016 оны 10-р сарын 03-ноос 10-р сарын 12-ныг дуусталх хугацаанд хийж гүйцэтгэв.

Нэр дэвшигчдийн сонгуулийн зардал**Бүлэг 1****1.1 Аймгийн ИТХурлын сонгуулийн зохион байгуулалтын талаар**

Сонгуулийн тухай хуулийн хүрээнд 2016 оны орон нутгийн сонгуулийн зохион байгуулалттай холбоотойгоор аймгийн ИТХурлын Тэргүүлэгчид дараах шийдвэрүүдийг гаргаж хэрэгжүүлсэн байна. Үүнд:

-Сонгуулийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8-д “санал авах өдрөөс 150 хоногийн өмнө аймгийн сонгуулийн тойргийг байгуулна” гэсэн заалтын хүрээнд 2016 оны 1-р сарын 29-ний өдрийн 07 тоот тогтоолоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн тоог 41-ээр, сонгуулийн тойргийн тоог 32 байхаар баталж, тойргийн дугаар, харьяалах нутаг дэвсгэр, тойргийн төвийг тогтоожээ.

-Сонгуулийн тухай хуулийн 152 дугаар зүйлийн 152.1-д заасан хугацаанд буюу ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 4-р сарын 25-ний өдрийн 27 тоот тогтоолоор аймгийн ИТХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог хуваарилан баталж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн тоо, сонгуулийн тойрог, мандатын тооны талаарх мэдээллийг Сонгуулийн ерөнхий хороо, аймгийн сонгуулийн хороонд хүргүүлжээ. Энэ тогтоолоор аймгийн ИТХ-ын сонгуулийн тойргийн мандатын тоог Алтанбулаг, Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Эрдэнэ, Эрдэнэсант зэрэг 8 сумын болон Зуунмод сумын Номт багийн тойрогт тус бүрд 2 мандат, бусад 23 тойрогт 1 мандат байхаар тогтоосон байна.

МУ-ын СЕХ-ний 2016 оны 4-р сарын 18-ний өдрийн 21 тоот тогтоолоор УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах аймгийн сонгуулийн хороодыг байгуулж, сумдын сонгуулийн хороо байгуулахыг аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосны дагуу сонгуулийн зохион байгуулалтын ажил хийгджээ.

УИХ болон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулсан аймгийн сонгуулийн хороог татан буулгах тухай МУ-ын СЕХ-ний 2016 оны 7-р сарын 07-ний өдрийн 262-р тогтоол гарсан байна. Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-хороонд 2016 оны 08-р сарын 03-нд тайлан мэдээгээ тушааж улмаар 2016 оны 08-р сарын 15-ний өдрөөр тасалбар болгон татан буугдсан байна.

Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд 32 тойрогт 114 нэр дэвшигч бүртгүүлэн нэр дэвшсэнээс 106 нэр дэвшигч сонгуулийн зардлын дансны тайланг хуулийн хугацаанд ирүүлсэн байна.

1.2 Нэр дэвшигч нарын зардлын тайлан ирүүлсэн талаар.

Төв аймгийн ИТХ-ын 2016 оны сонгуульд 27 сумын 32 тойрогт 41 мандатаар нэр дэвшигчдийг бүртгэн, аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 05-р сарын 16-ний өдрийн 03 дугаар тогтоолын хавсралтаар 114 нэр дэвшигчдийн нэрсийг баталсан байна. Үүнд:

- ✓ МАН-аас 27 сумын 32 тойрогт 41 нэр дэвшигч
- ✓ АН-аас 26 сумын 31 тойрогт 40 нэр дэвшигч
- ✓ МАХН-аас 19 сумын 24 тойрогт 24 нэр дэвшигч
- ✓ ХҮН-аас 3 сумын 7 тойрогт 8 нэр дэвшигч
- ✓ Баянчандмань сумын 12-р тойрогт 1 бие даан нэр дэвшигч

Сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 30

хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж заасны дагуу Төв аймгийн Сонгуулийн хороонд дараах нэр дэвшигч нар хугацаанд нь хүргүүлсэн байна. Үүнд:

- МАН-аас нэр дэвшсэн 41 нэр дэвшигч 100 хувь
- АН-аас нэр дэвшсэн 40 нэр дэвшигчээс 35 нэр дэвшигч буюу 87.5 хувь
- МАХН-аас нэр дэвшсэн 24 нэр дэвшигч 100 хувь
- ХҮН-аас нэр дэвшсэн 8 нэр дэвшигчээс 6 нэр дэвшигч буюу 75 хувь
- Баянчандмань сумын 12-р тойрогт бие даан нэр дэвшсэн 1 нэр дэвшигч тайлангаа өгсөн байна

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д “сонгуулийн зардлын тайлан, холбогдох бусад баримт бичгийг хүлээн авсан сонгуулийн байгууллага дараах төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ” 60.1.2-д “аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн байгууллага аймаг, нийслэлийн төрийн аудитын байгууллагад” гэж заасны дагуу аймгийн Сонгуулийн хороо, аймгийн Аудитын газарт нэр дэвшигчдийн зардлын тайланг ирүүлсэн байна.

Төв аймгийн ИТХ-д нэр дэвшигчдээс АН-ын 5 нэр дэвшигч, ХҮН-ын 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 59.1-д заасныг зөрчиж дараах 7 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа аймгийн сонгуулийн хороонд ирүүлээгүй байна. Үүнд:

- АН-аас Борнуур сумын 13-р тойрогт нэр дэвшигч М.Цэрэнчулуун, Бүрэн сумын 14-р тойрогт нэр дэвшигч Ж.Эрдэнэбат, Дэлгэрхаан сумын 15-р тойрогт нэр дэвшигч Ч.Энхбаатар, Цээл сумын 30-р тойрогт нэр дэвшигч Б.Лхамноров, Эрдэнэ сумын 31-р тойрогт нэр дэвшигч Н.Отгонбаяр,
- ХҮН-аас Зуунмод сумын 18-р тойрогт нэр дэвшигч Н.Биханзрагчаа, Сэргэлэн сумын 27-р тойрогт нэр дэвшигч Б.Өлзий-Орших нар.

Сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нэр дэвшигчдийн тухайд Сонгуулийн хуулийн 60 дугаар зүйлийн 60.5-д “Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах талаар аймгийн Аудитын газар нь 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр 1/489 тоот албан бичиг аймгийн Сонгуулийн хороонд хүргүүллээ.

1.3. Сонгуулийн зардлын дээд хэмжээ баримталсан талаар

Сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д “Орон нутгийн хурлын сонгуулийн тухайд төрийн аудитын дээд байгууллагаас тогтоосон жишигт нийцүүлэн аймаг, нийслэл дэх төрийн аудитын салбар байгууллага нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх орон нутгийн хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг санал авах өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө тогтооно” гэж заасны дагуу аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2016 оны 3-р сарын 28-ний өдрийн А/03 тоот тушаалаар аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 8.0-27.7 сая төгрөгөөр тогтоон баталсан.

Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд оролцсон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланг 106 нэр дэвшигч ирүүлсэн ба энэхүү батлагдсан зардлын дээд хэмжээнээс хэтрүүлсэн нэр дэвшигч байхгүй байна. /хавсралт №1/

1.4. Аймгийн ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансны талаар

Сонгуулийн тухай хуулийн 47.5-д “Аймаг, нийслэлийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь сонгуулийн зардлын данс нээлгэсэн өдрөөс хойш тав хоногийн дотор аймаг, нийслэлийн

сонгуулийн хороонд дансны дугаар, банкны нэрийг мэдэгдэж бүртгүүлэх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна. Нийт нэр дэвшигчийн дансны мэдээллийг сонгуулийн хорооноос авч сонгуулийн зардлын тайланг тулган шалгахад сонгуулийн хорооноос ирүүлсэн албан тоотонд дурьдсан дансны дугаартай банкны харилцах дансны дугаар тохирч байна. Өндөрширээт сумын 26-р тойрогт нэр дэвшигч Б.Оролзод нь сонгуулийн зардлын данс ашиглаагүй ХААН банк дахь өөрийн харилцах дансаар сонгуулийн зардлын гүйлгээ хийсэн байна.

МАХН-аас дараах тойрогт нэр дэвшигч нар нь сонгуулийн зардлын тайланд харилцах дансны хуулгыг ирүүлээгүй байна. Үүнд: Борнуур сумын 13-р тойрогт нэр дэвшигч Н.Лхавгацэрэн, Сэргэлэн сумын 27-р тойрогт нэр дэвшигч Б.Бадарч, Баянчандмань сумын 12-р тойрогт нэр дэвшигч Я.Алтаншагай, Эрдэнэсант сумын 32-р тойрогт нэр дэвшигч А.Очирпүрэв, Баянхангай сумын 9-р тойрогт нэр дэвшигч Г.Одгэрэл, Зуунмод сумын 20 дүгээр тойрогт нэр дэвшигч Х.Нарангэрэл, 22 дүгээр тойрогт нэр дэвшигч Ж.Цагаанбаатар, 23 дүгээр тойрогт нэр дэвшигч Т.Хүрэлбаатар, Баян сумын 5-р тойрогт нэр дэвшигч Ч.Бадамхатан, 16-р тойрогт нэр дэвшигч Г.Баяраа, Батсүмбэр сумын 4-р тойрогт нэр дэвшигч Б.Нандинцэцэг нар.

Аймгийн ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дансанд нийт 428572.4 мянган төгрөгийн мөнгөн ба мөнгөн бус хандив эх үүсвэр төвлөрүүлсэн байна.

Төв аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын мөнгөн хөрөнгийн дансанд 244 иргэнээс мөнгөн ба мөнгөн бус хандив 255515.0 мянган төгрөг, 6 хуулийн этгээдээс өгсөн хандив 6500.0 мянган төгрөг, намын хөрөнгө 8500.0 мянган төгрөг, нэр дэвшигчдийн өөрийн хөрөнгө 158057.4 мянган төгрөг нийт 428572.4 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна. /хавсралт №2/

Сонгуульд оролцсон зарим тойргийн нэр дэвшигчид хандивлагчдийн судалгаа тайланг гаргаж ирүүлээгүй байна. Үүнд: Аргалант сумын 2-р тойрогт АН-аас нэр дэвшигч Б.Удвал, Баянжаргалан сумын 8-р тойрогт АН-аас нэр дэвшигч Г.Дүүрэн, Баяндэлгэр сумын 7-р тойрогт АН-аас нэр дэвшигч Т.Баянжаргал, Баяндэлгэр сумын 7-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч С.Очирпүрэв, Баянжаргалан сумын 8-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч П.Алтанцэцэг, Борнуур сумын 13-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч Н.Лхавгацэрэн, Сэргэлэн сумын 27-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч Б.Бадарч нар.

Сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3-д “Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлнэ”, 59.4-т “... 59.3-т заасныг зөрчсөн банкны захирлыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан боловч хариуцлагын арга хэмжээг хэн хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

1.5 Сонгуулийн зардалын зарцуулалтын талаар

Аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангийн гүйцэтгэлээр 418329.0 мянган төгрөгийг сонгуулийн зардалд зарцуулжээ.

Төв аймгийн ИТХ-ын ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын зарцуулалтын тайлангаар мөнгөн хэлбэрээр 413983.5 мянган төгрөг, мөнгөн бус хэлбэрээр 4345.5 мянган төгрөг нийт 418329.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Нийт зардлын 47.8 хувь буюу 199369.4 мянган төгрөгийг нэр дэвшигчдийг сурталчлах, хурал цуглаан зохион байгуулах, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулахад зарцуулсан байна.

Зарцуулалтыг зардлын төрлөөр авч үзвэл:

- Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах зардал 70519.9 мянган төгрөг
- Нам, эвсэл, нэр дэвшигчийг сурталчлах зардал 85607.9 мянган төгрөг
- Сонгуулийн уулзалт, хурал, цуглаан зохион байгуулах зардал 43241.6 мянган төгрөг
- Бичиг хэргийн зардал 13238.5 мянган төгрөг
- Шуудан холбооны зардал 18358.9 мянган төгрөг
- Унааны зардал 75037.4 мянган төгрөг
- Албан томилолтын зардал 28590.8 мянган төгрөг
- Хөлс, урамшууллын зардал 82734.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Сонгуулийн зардлын тайлангаа зарим нэр дэвшигчид нь албан ёсны батлагдсан маягтаар гаргаагүй байна. Тухайлбал: Аргалант сумын 2-р тойрогт АН-аас нэр дэвшигч Б.Удвал, МАН-аас нэр дэвшигч Д.Баяр, МАХН-аас нэр дэвшигч Б.Хүрэлбаатар, Баяндэлгэр сумын 7-р тойрогт АН-аас нэр дэвшигч Т.Баянжаргал, МАХН-аас нэр дэвшигч С.Очирпүрэв, Баянжаргалан сумын 8-р тойрогт АН-аас нэр дэвшигч Г.Дүүрэн, МАХН-аас нэр дэвшигч П.Алтанцэцэг.

Төв аймгийн ИТХ-д нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын гүйцэтгэлд аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5 “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.6-д “Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна” гэсэн заалтууд зөрчигдөж анхан шатны баримтгүй, анхан шатны баримтаас зөрүүтэй, гарын үсэг зурж баталгаажуулаагүй тайлан ирүүлсэн зөрчилүүд байна. Тухайлбал:

- Зуунмод сумын 18-р тойрогт ХҮН-аас нэр дэвшигч Д.Дагважанцан нь урамшуулалыг хэдэн иргэнд олгосон нь тодорхойгүй анхан шатны баримтын бүрдэлгүй тайлагнасан.
- Зуунмод сумын 20-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч Х.Нарангэрэл нь нийт 3132.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй сонгуулийн сурталчилгааны зардалд зарцуулсан.
- Зуунмод сумын 22 -р тойрогт МАХН-аас нэр дэвшигч Ж.Цагаанбаатар нь анхан шатны баримтын бүрдэлгүй тайлан ирүүлсэн.
- Зуунмод сумын 23-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч Т.Хүрэлбаатар нь анхан шатны баримтгүй тайлан ирүүлсэн.
- Баянцагаан сумын 10-р тойрогт АН-аас нэр дэвшигч Ж.Ганбатын бэлтгэсэн тайлан нь бүрдүүлсэн анхан шатны баримтаас зөрүүтэй байсан.
- Борнуур сумын 13-р тойрогт МАХН-аас нэр дэвшигч Н.Лхавгацэрэн нь орлогын дэлгэрэнгүй тайлан ирүүлээгүй зэрэг.


Баянчандмань сумын 12-р тойрогт бие даан нэр дэвшигч Б.Батболд өөрийн хөрөнгө 930.0 мянган төгрөгийн орлогыг сонгуулийн зардлын дансанд оруулалгүйгээр зарцуулсан байна. Энэ нь Сонгуулийн тухай хуулийн 47.7-д “Нэр дэвшигч сонгуулийн зардлын дансандаа өөрийн хөрөнгө, хандивыг хуримтлуулна, 54.1-д “Нэр дэвшигч нь өөрийн хувийн орлогоор олсон мөнгөн хөрөнгийг нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд оруулан сонгуулийн зардал гаргана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Бүлэг 2

Нэр дэвшигчдийн сонгуулийн хандив

2.1. Нэр дэвшигчдийн хандив бүрдүүлэлтийн талаар

Аймгийн ИТХ-д нэр дэвшсэн 106 нэр дэвшигчдэд 244 иргэн, 6 хуулийн этгээд нийт 262015.0 мянган төгрөгийн хандив өгчээ.



Төв аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаар иргэн хуулийн этгээдээс 18 нэр дэвшигч хандив аваагүй. Харин 88 нэр дэвшигчийн мөнгөн хөрөнгийн дансанд 244 иргэнээс 255515.0 мянган төгрөг, 6 хуулийн этгээдээс 6500.0 мянган төгрөг нийт 262015.0 мянган төгрөгийн хандив төвлөрсөн байна.

Аймгийн ИТХуралд нэр дэвшигчид нь сонгуулийн хандивийг бүрдүүлэхдээ Сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтыг баримтлаагүй зөрчил гаргасан тохиолдлууд гарч байна. Тухайлбал:

1. Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-д “Иргэн, хуулийн этгээд нь нэг нам, эвсэл болон нэр дэвшигчид жилд зөвхөн нэг удаа хандив өгч болно” гэсэн заалт зөрчигдсөн байна:

- Баянчандмань сумын 12-р тойрогт МАН-аас нэр дэвшигч Б.Алтан-Очирт иргэн Ч.Самбуудорж 2016 оны 5-р сарын 30-нд 1.0 сая төгрөг, 2016 оны 6-р сарын 24-нд 2.0 сая төгрөг, нийт 3.0 сая төгрөгийн хандив өгсөн.
- Баянчандмань сумын 12-р тойрогт МАН-аас нэр дэвшигч Б.Мөнхбаатарт иргэн Д.Батжаргал 2016 оны 6-р сарын 20-нд 1.0 сая төгрөг, 2016 оны 6-р сарын 24-нд 0.5 сая төгрөг, иргэн Д.Мөнх-Эрдэнэ 2016 оны 6-р сарын 09-нд 0.8 сая төгрөг, 2016 оны 6-р сарын 21-нд 0.95 сая төгрөгийн хандив өгсөн.
- Баяндэлгэр сумын 7-р тойрогт МАН-аас нэр дэвшигч Д.Алтанцэцэгт иргэн Б.Амаржаргал 2016 оны 6-р сарын 17-нд 0.5 сая төгрөгөөр 2 удаа, 2016 оны 6-р сарын 23-нд 0.3 сая төгрөгийн хандив өгчээ.

2. Сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.4-д “мөнгөн бус хандивын үнэлгээг хандивын гэрээгээр харилцан тогтоох бөгөөд уг үнэлгээ нь иргэн болон хуулийн этгээдээс өгөх хандивын дээд хэмжээнээс хэтрэхгүй байна” гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй байна.

- Баянчандмань суманд АН-аас нэр дэвшигч Б.Эрдэнэчимэг, Г.Оргил нарын сонгуулийн зардалд байр түрээслэсэн мөнгөн бус хандивын гэрээнд хандивын үнэлгээг тохиролцоогүйгээс үнэлгээгүйгээр хийсэн.
- Баянхангай суманд МАХН-аас нэр дэвшигч Г.Одгэрэл сонгуулийн зардлын мөнгөн бус хандивыг авахдаа Сонгуулийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-д “Мөнгөн бус хандив өгч байгаа тохиолдолд хандивлагч нь нэр дэвшигч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй бичгээр хандивын гэрээ байгуулна” гэж заасныг баримтлалгүй гэрээгүйгээр хандив авч орлого, зарлагыг тайлагнасан.

3. Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна. Нийт мөнгөн хандивын 33 нэр дэвшигчийн 63 иргэнээс авсан 28942.0 мянган төгрөгийн мөнгөн ба мөнгөн бус хандивыг хуульд заасан регистрийн дугааргүйгээр хүлээн авч сонгуулийн зардалд зарцуулсан байна. /хавсралт №2/

Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.9-д “Энэ хуулийн 50.2-т заасныг зөрчсөн үйлдэлд доор дурдсан хэмжээний торгууль ногдуулна”, 50.9.1-д “иргэнд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн”, 50.9.2-д “хуулийн этгээдэд нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгийн торгууль ногдуулна” гэсэн заалт байгаа боловч хэн хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна.

Сонгуулийн тухай хуулийн 50.4-д заасан заалтыг хэрэгжүүлэн регистрийн дугааргүй хандивыг Баянцогт сумын 11-р тойрогт АН-аас нэр дэвшигч М.Шаарийбуу нь 0.5 сая төгрөгийг, Зуунмод сумын 19 дүгээр тойрогт ХҮН-аас нэр дэвшигч Д.Пүрэвдаш нь 0.5 сая төгрөгийг, Баяндэлгэр сумын 7-р тойрогт нэр дэвшигч Д.Алтанцэцэг нь 0.55 сая төгрөгийг, Зуунмод сумын 22 дүгээр тойрогт АН-аас нэр дэвшигч Ж.Цэндсүрэн нь нийт 2.1 сая төгрөгийг буцаан шилжүүлсэн байна.

2.2. Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн талаар.

Аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшсэн 88 нэр дэвшигч нь 244 иргэнээс 255515.0 мянган төгрөгийн, 6 хуулийн этгээдээс 6500.0 мянган төгрөгийн нийт 262015.0 мянган төгрөгийн хандив авсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-т “Төрийн аудитын байгууллага зардлын тайланг хянаж, хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана” гэж заасан.

Төв аймгийн ИТХ-ын сонгуульд оролцсон нэр дэвшигчдээс хуулийн дээрх заалт буюу 1 сая төгрөгөөс дээш хандив өгсөн иргэн, 2 сая төгрөгөөс дээш хандив өгсөн хуулийн этгээдтэй хамааралтай 50 нэр дэвшигчид байна. Эдгээр нэр дэвшигчид нь 110 иргэнээс 159455.0 мянган төгрөг, 1 хуулийн этгээдээс 3000.0 мянган төгрөгийн нийт 162455.0 мянган төгрөгийн хандив авсан байна.

Аймгийн ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчдэд иргэн хуулийн этгээдээс нийт 262015.0 мянган төгрөгийн хандив төвлөрсөнөөс сонгуулийн тухай хуулийн 60.3-д заасны дагуу нийтэд мэдээлэх 162455.0 мянган төгрөгийн хандив байна

Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн 16 иргэдийн регистрийн дугаар байхгүй байна. Эдгээр 16 иргэн нь 9 нэр дэвшигчдэд 18.5 сая төгрөгийн хандив өгчээ. Регистрийн дугааргүй иргэдээс өгсөн хандивийг авч зарцуулсан нь Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалт.

№	Нам	Нэр дэвшигчдийн эцэг /эх/ -ийн нэр, өөрийн нэр	Хандивлагч иргэний эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр	РД	Мөнгөн дүн	Хандивлагч хуулийн этгээдийн нэр	Мөнгөн дүн
1	АН	У.Болормаа	С.Туяа	???	1,000.0		
2	АН	Т.Алтаншагай	Б.Лхагвасүрэн	???	1,000.0		
3	МАН	Н.Мөнхсайхан	М.Гэрэлтуяа	ну 88081929	1,100.0		
4	АН	А.Төмөрсүх	С.Туяа	зм 71072402	1,000.0		
5	МАН	Д.Ганбаяр	Г.Баясгаланбаатар	нб 81120933	3,000.0		
			Г.Гэрэлмаа	нб 88092504	1,000.0		
			О.Бадамгарав	уе 81081145	3,000.0		
6	МАН	Г.Бат-эрдэнэ	Галт Батболд	АМ 70022011	2,000.0		
			Б.Баттулга	ам 83081936	1,000.0		
			Г.Болор-эрдэнэ	ЦГ 67092415	2,160.0		
			Б.Батням	ШЖ 78120331	1,000.0		
7	АН	Б.Удвал	Т.Эрдэнэ	чс64030116	1,000.0		
8	МАХН	Д.Алтанцэцэг	Б.Амаржаргал	ЗЮ69110100	1,300.0		
			А.Энхнаст	НЧ474112173	1,000.0		
9	АН	Г.Дүүрэн	trf=000-АТМ7	???	1,000.0		
			Хүүлийханаас	???	1,000.0		
			Гэрэлт	???	1,500.0		
			Сангидорж	???	1,000.0		
			С.Нямдэлгэр	???	1,000.0		
			ШИжээ	???	2,000.0		
10	АН	Б.Батбаатар	Б.Баатарзоригт	НД79031591	1,500.0		
11	МАН	Г.Эрдэнэбаяр	Н.Нармандах	УС87121715	1,000.0		
			Л.Үржинханд	НВ61100602	1,000.0		
12	АН	Б.Наранбат	Д.Батбаяр	НЭ68073078	2,000.0		
			Б.Мөнхжаргал	НО62121675	3,000.0		
13	МАН	С.Цагаанбаатар	А.Наранцэцэг	НН65123064	2,000.0		
14	МАН	Б.Алтан-Очир	Б.Байгалмаа	Ч362051520	1,000.0		
			Ч. Самбуудорж	ШЕ54081004	3,000.0		
			Ц.Цэрэн -Очир	МА83012013	2,000.0		
15	МАН	Д.Мөнхбаатар	Б.Байгалмаа	Ч362051520	2,000.0		
			Н.Одхүү	НХ74050431	1,000.0		
			Д.Мөнх-Эрдэнэ	НХ90072512	1,750.0		

			Д.Батжаргал	НГ78031979	1,500.0		
16	АН	С.Лхүндэврэгзэн	Д. Лхагвасүрэн	???	1,000.0		
			Тунгалаг	ХЙ88022506	2,850.0		
17	АН	Ц.Тэрбиш	Т.Батбаатар	НФ83121113	2,850.0		
			Д.Лхагвасүрэн	ЧС77110975	1,000.0		
18	МАН	С.Баярмаа	С.Хатанбаатар	НЫ81041677	1,000.0		
			С.Болдбаатар	НЫ83032075	1,000.0		
			Л.Цэцэгмаа	ИЮ56081007	2,000.0		
			Г.Дуламханд	НЫ86032863	1,300.0		
19	АН	Х.Уламсайхан	Т.Эрдэнэ	ЧС64030116	1,000.0		
20	МАН	Ц.Жамбалсүрэн	Ц.Пүрэвсүрэн	НИ77082411	1,000.0		
			Т.Даарийжав	Ни69040919	1,000.0		
			Ц.Ламчин	Ни70092119	1,600.0		
21	АН	М.Шаарийбуу	Д.Лхагвасүрэн	???	1,000.0	Сүвэн-Уул ХХК	3,000.0
22	МАН	Р.Болд	Цэрэндорж	ЧЖ43011216	1,000.0		
23	АН	Х.Оюунчимэг	Т.Эрдэнэ	ЧС64030116	1,000.0		
			Х.Оюунгэрэл	ЧТ54021908	2,500.0		
24	АН	Г.Энх-Амгалан	С.Туяа	ЗМ71072402	1,000.0		
			Ц.Ганбаатар	НФ57080218	1,000.0		
			Г.Энхбат	НФ84121609	1,000.0		
25	МАН	Ц.Дашдэмбэрэл	Д.Цэрэндаваа	НК55062518	1,000.0		
			Э.Доржсүрэн	НК83071218	1,500.0		
			Х.Алтангэрэл	НК83092415	2,200.0		
26	АН	Д.Баярбат	С.Энхболд	УХ66091910	1,000.0		
			Ц.Ууганбаяр	ЙК84123030	2,680.0		
27	МАН	Ж.Батжаргал	П.Мөнх-Эрдэнэ	ЧН68011211	1,000.0		
			Ж.Уранчимэг	НТ60021084	1,000.0		
			Д.Мөнхбаатар	НХ78082611	1,000.0		
			Ж.Амгалан	НГ70070668	1,000.0		
			Ц.Ариунцэцэг	НГ74090168	1,000.0		
			Д.Баярцэцэг	НЮ86092465	1,000.0		
28	АН	Ж.Цэндсүрэн	Ш.Оюундарь	НЭ73083066	3,000.0		
			Эрдэнэчимэг	ШБ81071603	2,500.0		
			З.Оюунцэцэг	НЭ70031226	2,200.0		
29	АН	Ж.Батцэнгэл	Ч.Болор	ЧВ69022219	1,000.0		
			Б.Баатарчулуун	???	2,000.0		
30	АН	Д.Лхамсүрэн	Г.Одгийв	ЧР79053074	2,000.0		
31	МАН	Р.Очирбат	Э.Санчир	ЧС83010777	1,500.0		
32	АН	Ж.Ганбат	С.Туяа	ЗМ71072402	1,000.0		
33	АН	Ч.Дашдэмбэрэл	Б.Баатаржав	ХБ75111672	1,000.0		
34	МАН	Ц.Энхбат	Ц.Энхсайхан	НЗ67052577	1,700.0		
			Ц.Амгаланбаатар	НЗ69090775	2,000.0		
			Д.Батжаргал	НГ78031979	1,000.0		
			Х.Мөнхжаргал	НЗ86011476	2,000.0		
35	МАН	Ц.Гүйнбаатар	Ц.Дамба	???	1,000.0		
			Б.Цэнд-Аюуш	???	1,000.0		
			Н.Дэнсмаа	???	1,000.0		
			Б.Нижиннаш	УХ67050532	1,000.0		
36	МАН	Ж.Баттөгс	Ц.Энхбаатар	ЙЭ63030119	2,000.0		
37	АН	Ц.Батэрдэнэ	Ч.Болор	ЧВ69022219	1,000.0		
38	АН	М.Нямсүрэн	Б.Баатаржав	ХБ75111672	1,000.0		
39	МАН	Б.Цэрэнбат	Б.Баттулга	хг79101319	2,000.0		
			Э.Эрдэнэхорол	уш91010241	2,000.0		
			М.Төгсжаргал	уш79102318	2,500.0		

40	МАН	Д.Цэцгээ	Д.Чанцал	нл79110266	1,785.0		
41	АН	Э.Болормаа	Оюунболд	ню85112276	2,000.0		
42	МАН	Ц.Батдорж	Г.Дэлгэрцэцэг	уг81120301	1,000.0		
43	МАН	Ц.Эрдэнэбаатар	Д.Сэрдсүрэн	НГ57121061	1,500.0		
			Бямбадорж	НГ8602571	1,000.0		
			Б.Чойжамц	НГ9507218	1,000.0		
			Л.Цэцэгдэлгэр	ШД64051665	1,000.0		
44	МАН	Б.Нямдорж	Б.Ганзориг	НХ85121614	1,000.0		
			Н.Энхболд	???	1,000.0		
			П.Оюун-Эрдэнэ	ГМ 86040506	1,200.0		
			Л.Амаржаргал	НН86021767	2,780.0		
45	МАН	М.Энхтайван	Н.Энхболд	???	1,000.0		
			Н.Батчимэг	НН78073065	1,000.0		
			А.Мөнхбат	НН71081570	1,000.0		
			М.Буянханд	НН72060265	1,000.0		
			Н.Наранхүү	НН64081378	1,000.0		
46	АН	Д.Болормаа	Х.Мөнхмаа	ШД85041166	1,000.0		
			Х.Дуламням	НХ70071908	1,000.0		
			А.Оюунболд	ЛЮ85112276	1,000.0		
47	АН	С.Амгаланбаатар	Г.Болдбаатар	НН65062219	1,000.0		
48	АН	Ц.Мэндсайхан	Х.Ганбаяр	ШЕ79053018	1,500.0		
			Б.Цэнгэл	ЧЛ61081975	1,000.0		
49	МАН	А.Өнөржаргал	Т.Тунгалаг	НЭ82050205	3,000.0		
50	АН	Т.Баяржаргал	Ч.Болор	ЧВ69022219	1,000.0		
		ДҮН			159,455.0		3,000.0

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

1. Аймгийн Сонгуулийн хороо нь аймгийн ИТХ-ын ээлжит сонгуулийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан байна.
2. Төв аймгийн сонгуулийн хороонд АН-ын 5 нэр дэвшигч, ХҮН-ын 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй нь Сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасныг зөрчсөн байна.
3. Зарим нэр дэвшигчдийн ирүүлсэн тайлан нь анхан шатны баримтгүй, анхан шатны баримтаас зөрүүтэй, гарын үсэг зурж баталгаажуулаагүй зөрчилтэй байна.
4. Нэр дэвшигчийн сонгуулийн зардлын данс байршуулсан банкны захирал, эсхүл салбарын эрхлэгч нь уг дансны бүх гүйлгээг нэгтгэсэн тайлан гаргаж, санал хураалт дууссан өдрөөс хойш 45 хоногийн дотор тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлнэ гэсэн заалт огт хэрэгжээгүй байна.
5. Нэр дэвшигчидийн сонгуулийн хандивтай холбоотой хуулийн 50 дугаар зүйлийн 50.2, 50.4, 51 дүгээр зүйлийн 51.4-д заасан заалтууд зөрчигдсөн байна.
6. Хуульд сонгуулийн хууль тогтоомж зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээг тодорхой тусгасан боловч хэн хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүйгээс хууль зөрчсөн зөрчлүүдэд хүлээлгэсэн хариуцлага байхгүй байна.

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн:

Аймгийн ИТХурлын сонгуульд оролцсон улс төрийн Намуудын удирдах байгууллага, удирдлагад зөвлөх нь:

1. Сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4-д “Хандив өгч байгаа иргэн, хуулийн этгээд нь регистрийн дугаараа банкны гүйлгээний баримтад заавал тусгах бөгөөд энэ шаардлагыг хангаагүй хандивыг хандив хүлээн авагч буцаан шилжүүлнэ” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

АН, ХҮН-ын дарга, удирдлагад зөвлөх нь:

1. Сонгуулийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн хурлын сонгуульд нэр дэвшигч нь санал хураалт явагдсан өдрөөс хойш 30 хоногт багтаан сонгуулийн зардлын тайлан гаргаж тухайн шатны сонгуулийн байгууллагад хүргүүлэх үүрэгтэй” гэж заасныг мөрдлөг болгон нийт нэр дэвшигчдийн тайланг хугацаанд ирүүлж байх
2. Сонгуулийн тухай хуулийн 50, 51, 59-р зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэн нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайланг маягтын дагуу бүрэн хөтлөж, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

ХЯНАСАН:
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР



Л. ЖАРГАЛСАЙХАН

О.АМАРЖАРГАЛ

Т.МАЙЦЭЦЭГ

Ц.БАЗАРСАД

№	Нам, эвслийн нэр	Тоирогийн дугаар	Нэр дэвшигчдийн Овог нэр	Хуулийн этгээд эс өгсөн хандив	Иргэдээс өгсөн хандив	Намын өөрийн хөрөнгө	Нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө	Орлогын дүн	Зардлын дээд хэмжээ	Зардлын гүйцэтгэл
1	АН	16	Н.Энхболд	0.0	366.0	1000.0	4120.0	5486.0	25500.0	5486.0
2	АН	16	Д.Ганболд	0.0	400.0	1000.0	4700.0	6100.0	25500.0	6100.0
3	МАХН	4	Б.Нандинцэцэг	0.0	682.0	0.0	0.0	682.0	27700.0	682.0
4	МАХН	16	Г.Баяраа	0.0	0.0	0.0	2000.0	2000.0	25500.0	2000.0
5	АН	4	У.Болормаа	0.0	1501.0	1000.0	0.0	2501.0	27700.0	2501.0
6	АН	4	Т.Алтаншагай	0.0	1501.0	1000.0	0.0	2501.0	27700.0	2500.0
7	МАН	31	Н.Мөнхсайхан	0.0	4000.0	0.0	1001.0	5001.0	17000.0	4996.2
8	АН	31	А.Төмөрсүх	0.0	1011.0	1000.0	0.0	2011.0	17000.0	2000.0
9	МАН	4	Ц.Цогзолмаа	0.0	530.0	0.0	1054.0	1584.0	27700.0	1579.9
10	МАН	4	Д.Ганбаяр	0.0	7000.0	0.0	75.4	7075.4	27700.0	7000.7
11	МАН	16	Т.Цолмонгэрэл	0.0	0.0	0.0	4650.0	4650.0	25500.0	4650.0
12	МАН	16	Г.Бат-эрдэнэ	0.0	6160.0	0.0	600.0	6760.0	25500.0	6760.0
13	МАН	31	Ж.Нямсүрэн	0.0	1650.0	0.0	101.0	1751.0	17000.0	1748.3
14	МАН	2	Д.Баяраа	0.0	0.0	0.0	3960.0	3960.0	8000.0	3960.0
15	АН	2	Б.Удвал	0.0	2001.0	500.0	0.0	2501.0	8000.0	2500.3
16	МАХН	2	Б.Хүрэлбаатар	0.0	0.0	0.0	1000.0	1000.0	8000.0	1000.0
17	МАН	7	Д.Алтанцэцэг	0.0	3510.0	0.0	107.0	3617.0	8400.0	3617.0
18	АН	7	Т.Баяржаргал	0.0	1751.0	0.0	499.8	2250.8	8400.0	2201.4
19	МАХН	7	С.Очирпүрэв	0.0	500.0	0.0	0.0	500.0	8400.0	500.0
20	МАН	8	Г.Бямбадорж	0.0	0.0	0.0	4987.3	4987.3	8400.0	4987.3
21	АН	8	Г.Дүүрэн	0.0	7501.1	1000.0	0.0	8501.1	8400.0	8492.9
22	МАХН	8	П.Алтанцэцэг	0.0	500.0	0.0	0.0	500.0	8400.0	500.0
23	АН	3	Б.Батбаатар		2001.0	0.0	850.0	2851.0	7500.0	2846.6
24	МАН	3	Г.Эрдэнэбаяр		4960.0	0.0	1000.0	5960.0	7500.0	5960.0
25	АН	24	Б.Наранбат		6301.0	0.0	0.0	6301.0	11800.0	6301.0
26	МАН	24	А.Оюунчимэг		0.0	0.0	3000.0	3000.0	11800.0	2994.7
27	МАХН	24	Ц.Даваадорж		700.0	0.0	0.0	700.0	11800.0	700.0
28	МАХН	30	М.Ганбат		880.0	0.0	1500.0	2380.0	11500.0	2379.3
29	МАН	30	С.Цагаанбаатар		2500.0	0.0	1320.0	3820.0	11500.0	3820.0
30	БДаагч	12	Б.Батболд	0.0	1299.9	0.0	930.0	2229.9	16800.0	2229.9
31	АН	12	Б.Эрдэнэчимэг	0.0	1009.0	0.0	0.0	1009.0	16800.0	1009.0
32	МАН	12	Б.Алтан-Очир	0.0	6000.0	0.0	2000.0	8000.0	16800.0	8000.0
33	МАН	12	Д.Мөнхбаатар	0.0	7950.0	0.0	1000.0	8950.0	16800.0	8950.0
34	МАХН	12	Я.Алтаншагай	0.0	100.0	0.0	0.0	100.0	16800.0	100.0
35	АН	12	Г.Оргил	0.0	1009.0	0.0	0.0	1009.0	16800.0	1009.0
36	АН	32	С.Лхүндэврэгзэн	0.0	3851.0	1000.0	1000.0	5851.0	19700.0	5851.0
37	АН	32	Ц.Тэрбиш	0.0	4351.0	0.0	400.0	4751.0	19700.0	4751.0
38	МАН	32	Ц.Буманбуян	500.0	700.0	0.0	1300.0	2500.0	19700.0	2500.0
39	МАН	32	Т.Мөнхзориг	500.0	3370.0	0.0	408.0	4278.0	19700.0	4278.0
40	МАХН	32	А.Очирпүрэв	0.0	0.0	0.0	500.0	500.0	19700.0	500.0
41	МАН	9	С.Баярмаа	0.0	6140.0	0.0	420.0	6560.0	7500.0	6559.7
42	АН	9	Х.Уламсайхан	0.0	2157.5	0.0	0.0	2157.5	7500.0	2109.1
43	МАХН	9	Г.Одгэрэл	0.0	500.0	0.0	0.0	500.0	7500.0	500.0
44	МАН	11	Ц.Жамбалсүрэн	0.0	4100.0	0.0	2050.0	6150.0	9100.0	6145.5
45	АН	11	М.Шаарийбуу	3000.0	1201.0	0.0	1117.0	5318.0	9100.0	4816.4
46	МАН	18	Р.Болд	0.0	2100.0	0.0	9001.0	11101.0	13000.0	11101.0

47	МАН	18	Г.Мөнхбадрал	0.0	3730.0	0.0	3322.9	7052.9	13000.0	7052.8
48	АН	18	Х.Оюунчимэг	0.0	4051.0	0.0	2000.0	6051.0	13000.0	6051.0
49	АН	18	Г.Энх-амгалан	0.0	3000.0	0.0	1820.0	4820.0	13000.0	3976.8
50	МАХН	18	Г.Оюунтуяа	0.0	1170.0	0.0	185.0	1355.0	13000.0	1355.0
51	ХҮН	18	Д.Дагважамцан	0.0	1000.0	0.0	0.0	1000.0	13000.0	1000.0
52	МАН	19	А.Шаравнямбуу	0.0	0.0	0.0	1501.5	1501.5	13000.0	1501.5
53	АН	19	Б.Хатанбаатар	0.0	1.0	0.0	5001.0	5002.0	13000.0	5002.0
54	МАХН	19	Ч.Наранцэцэг	0.0	453.0	0.0	0.0	453.0	13000.0	453.0
55	ХҮН	19	Д.Пүрэвдаш	0.0	800.0	0.0	1026.4	1826.4	13000.0	1826.4
56	МАН	20	Ц.Дашдэмбэрэл	0.0	5400.0	0.0	2905.0	8305.0	13000.0	5282.8
57	АН	20	Д.Баярбат	1000.0	3680.0	0.0	1500.0	6180.0	13000.0	6180.0
58	МАХН	20	Х.Нарангэрэл	0.0	1770.0	0.0	1362.0	3132.0	13000.0	3132.0
59	ХҮН	20	Ө.Уранчимэг	0.0	80.0	0.0	504.0	584.0	13000.0	584.0
60	МАН	21	Н.Дугар	0.0	1400.0	0.0	5512.0	6912.0	13000.0	6912.0
61	АН	21	З.Эрдэнэбаатар	0.0	1300.0	0.0	1001.0	2301.0	13000.0	2217.1
62	МАХН	21	А.Өнөржаргал	0.0	3000.0	0.0	0.0	3000.0	13000.0	2910.0
63	МАН	22	Н.Энхбаатар	0.0	8120.0	0.0	10.0	8130.0	13000.0	8130.0
64	АН	22	Л.Даваасамбуу	0.0	332.5	0.0	4983.1	5315.6	13000.0	5306.6
65	МАХН	22	Ж.Цагаанбаатар	0.0	0.0	0.0	1500.0	1500.0	13000.0	1500.0
66	ХҮН	22	Д.Сандуйжамц	0.0	20.0	0.0	500.0	520.0	13000.0	520.0
67	МАН	23	Ж.Батжаргал	0.0	6900.0	0.0	1501.0	8401.0	13000.0	8052.7
68	АН	23	Ж.Цэндсүрэн	0.0	11100.0	0.0	1500.0	12600.0	13000.0	12600.0
69	МАХН	23	Т.Хүрэлбаатар	0.0	700.0	0.0	0.0	700.0	13000.0	700.0
70	ХҮН	23	Д.Жавхаа	0.0	0.0	0.0	250.0	250.0	13000.0	250.0
71	МАН	28	С.Мөнхтүвшин	0.0	4330.0	1000.0	0.0	5330.0	8700.0	5330.0
72	АН	28	Ч.Цэдэнбал	0.0	901.0	0.0	999.8	1900.8	8700.0	1900.8
73	МАН	29	Ц.Энхболд	0.0	0.0	0.0	9000.0	9000.0	11400.0	8966.0
74	АН	29	Ж.Батцэнгэл	0.0	3001.0	0.0	0.0	3001.0	11400.0	3001.0
75	МАХН	26	Б.Оролзод	0.0	1120.0	0.0	181.9	1301.9	9600.0	1301.9
76	МАН	26	Б. Жаргалмаа	0.0	3380.0	0.0	2000.0	5380.0	9600.0	5380.0
77	АН	26	Д.Лхамсүрэн	0.0	3201.0	0.0	1000.0	4201.0	9600.0	4193.1
78	МАН	14	Р.Очирбат	0.0	2130.0	0.0	0.0	2130.0	13700.0	2128.3
79	МАН	5	Ж.Баттөгс	0.0	2000.0		4000.0	6000.0	10000.0	6000.0
80	МАН	13	Ц.Гүенбаатар	500.0	4620.0		2500.0	7620.0	21600.0	7452.0
81	МАН	10	Ц.Энхбат	0.0	6700.0		2001.0	8701.0	10000.0	8682.7
82	МАХН	13	Н.Лхагвацэрэн	0.0	0.0		2000.0	2000.0	21600.0	2000.0
83	МАХН	5	Ч.Бадамхатан	0.0	500.0		0.0	500.0	10000.0	500.0
84	АН	5	Ч.Дашдэмбэрэл	0.0	1000.0		500.0	1500.0	10000.0	1500.0
85	МАН	13	Б.Ганбат	0.0	0.0		9016.6	9016.6	21600.0	8736.7
86	АН	10	Ж.Ганбат	0.0	3011.0		1910.0	4921.0	10000.0	4440.7
87	АН	1	Ц.Батэрдэнэ	0.0	1001.0	0.0	0.0	1001.0	15400.0	999.5
88	АН	1	М.Нямсүрэн		1001.0	0.0	2500.0	3501.0	15400.0	1620.4
89	МАН	1	Д.Батсуурь	0.0	0.0	0.0	7400.0	7400.0	15400.0	7217.0
90	МАН	1	Б.Цэрэнбат	0.0	6950.0	0.0	5.0	6955.0	15400.0	5901.7
91	МАХН	1	Ш.Төмөрчөдөр	0.0	0.0	0.0	4700.0	4700.0	15400.0	4700.0
92	ХҮН	15	Д. Пүрэвдаш	0.0	0.0	0.0	3901.0	3901.0	8200.0	3877.3
93	МАН	15	Д.Цэцгээ	0.0	2685.0	0.0	1215.2	3900.2	8200.0	3900.2
94	АН	25	Э.Болормаа	0.0	2801.0	0.0	1000.0	3801.0	10200.0	3800.2
95	МАН	25	Ц.Батдорж	0.0	3990.0	0.0	3090.0	7080.0	10200.0	6889.3
96	МАН	6	Ц.Эрдэнэбаатар	0.0	6250.0	0.0	0.0	6250.0	10300.0	6250.0
97	МАХН	6	М.Батболд	0.0	1400.0	0.0	0.0	1400.0	10300.0	630.7
98	МАН	17	Б.Нямдорж	0.0	6880.0	0.0	150.0	7030.0	21800.0	7026.8

99	МАН	17	М.Энхтайван	1000.0	5000.0	0.0	950.0	6950.0	21800.0	6942.3
100	МАХН	15	Э.Азбилэг	0.0	500.0	0.0	0.0	500.0	8200.0	500.0
101	АН	17	С.Амгаланбаатар	0.0	5200.0	0.0	0.0	5200.0	21800.0	5200.0
102	АН	17	Д.Болормаа	0.0	5200.0	0.0	2100.5	7300.5	21800.0	7300.5
103	МАН	27	А.Идэрпүрэв	0.0	5150.0	0.0	0.0	5150.0	10700.0	5131.2
104	МАХН	27	Б.Бадарч	0.0	0.0	0.0	400.0	400.0	10700.0	400.0
105	АН	27	Ц.Мэндсайхан	0.0	3861.0	0.0	0.0	3861.0	10700.0	3859.0
106	МАХН	17	Л.Гансүх		0.0		1000.0	1000.0	21800.0	1000.0
			ДҮН	6500.0	255515.0	8500.0	158057.4	428572.4		418329.0

А. Иргэдээс өгсөн хандив

нэр дэвшигч	Нэр дэвшигчийн			№	Хандивлагч иргэний эцэг, /эх/-ийн нэр, өөрийн нэр	Регистрийн дугаар	Хандивын хэмжээ		
	Нам эвслийн нэр	тойргийн дугаар	Овог нэрс				Мөнгөн	Мөнгөн бус	ДҮН
1	АН	16	Нямаагийн Энхболд	1	Жигмэддорж	???	1.0		1.0
				2	???	???	265.0		265.0
				3	???	???	50.0		50.0
				4	???	???	50.0		50.0
					А-гийн дүн		366.0		366.0
2	АН	16	Дугарсүрэнгийн Ганболд	5	Мэндээ дүү	???	100.0		100.0
				6	Отгоноо	???	100.0		100.0
					А-гийн дүн		200.0		200.0
3	МАХН	4	Баярсайханы Нандинцэцэг	7	Д.Сэлэнгэ	???		182.0	182.0
					А-гийн дүн			182.0	182.0
4	АН	4	Уртнасангийн Болормаа	8	Жигмэддорж	???	1.0		1.0
				9	С.Туяа	???	1,000.0		1,000.0
					А-гийн дүн		1,001.0		1,001.0
5	АН	4	Төмөрбаатарийн Алтаншагай	10	Жигмэддорж	???	1.0		1.0
				11	Б.Лхагвасүрэн	???	1,000.0		1,000.0
				12	М.Мөнхбаатар	???	500.0		500.0
					А-гийн дүн		1,501.0		1,501.0
6	АН	31	Алагсандрийн Төмөрсүх	13	Жигмэддорж	???	1.0		1.0
					А-гийн дүн		1.0		1.0
7	АН	2	Батжавын Удвал	14	Жигмэддорж	???	1.0		1.0

				15	ЭВ. Алтангэрэл	???	500.0		500.0
					А-гийн дүн	???	501.0		501.0
8	АН	7	Тангадын Баяржаргал	16	Жигмэддорж	???	1.0		1.0
					А-гийн дүн		1.0		1.0
9	АН	8	Гончигравжа агийн Дүүрэн	17	Жигмэддорж	???	1.0		1.0
				18	trf=00016379373 4****000065АТ М752-АТМ7	???	1,000.0		1,000.0
				19	Хүүлийханаас	???	1,000.0		1,000.0
				20	Гэрэлт	???	1,500.0		1,500.0
				21	Сангидорж	???	1000.0		1,000.0
				22	С.Нямдэлгэр	???	1000.0		1,000.0
				23	ШИЖЭЭ	???	2000.0		2,000.0
					А-гийн дүн		7,501.0		7,501.0
10	МА ХН	8	Пүрэвийн Алтанцэцэг	24	????	???	500.0		500.0
					А-гийн дүн		500.0		500.0
11	МА ХН	24	Цэдэнбазар н Даваадорж	25	Ч.Батсайхан	???	400.0		400.0
				26	Н. Цэнд-аюуш	???	300.0		300.0
					А-гийн дүн		700.0		700.0
12	МА ХН	12	Яримпилийн Алтаншагай	27	М.Нацагдорж	???	100.0		100.0
					А-гийн дүн		100.0		100.0
13	МА ХН	32	Сэрээтэрийн Лхүндэврэгээ н	28	Д. Лхагвасүрэн	???	1000.0		1000.0
					А-гийн дүн	???	1000.0		1000.0
14	МА Н	32	Тогоохүүгий н Мөнхзориг	29	???	???	150.0		150.0
				30	???	???	150.0		150.0
					А-гийн дүн		300.0		300.0
15	МА Н	9	Сүхбаатарын Баярмаа	31	Э.Ичинноров	???	30.0		30.0
				32	М. Тунгалаг	???	30.0		30.0
					А-гийн дүн		60.0		60.0
16	АН	9	Хуягийн Уламсайхан	33	Бат	???	500.0		500.0
				34	С.Мөнгөнчимэг	???	157.0		157.0

					А-гийн дүн		657.0		657.0
17	АН	11	Мөнхийн Шаарийбуу	35	Эрдэнсүвд	???	200.0		200.0
				36	Д.Лхагвасүрэн	???	1000.0		1000.0
					А-гийн дүн		1200.0		1200.0
18	МАН	18	Раднаасэдийн Болд	37	Г.Батжаргал	???	100.0		100.0
					А-гийн дүн		100.0		100.0
19	ХҮН	18	Доржбилэгийн Дагважанцан	38	Энхбат	???	250.0		250.0
				39	???	???	250.0		250.0
				40	Цэрэнпил	???	500.0		500.0
					А-гийн дүн		1,000.0	-	1,000.0
20	МАНХН	8	Гэндэнгийн Оюунтуяа	41	Б.Сонинхүү	???	30.0		30.0
				42	Л.Оюун-Эрдэнэ	???	50.0		50.0
					А-гийн дүн	???	80.0		80.0
21	МАНХН	20	Хорлоогийн Нарангэрэл	43	О.Батчулуун	???	50.0		50.0
					А-гийн дүн		50.0		50.0
22	ХҮН	22	Даваасүрэнгийн Сандуйжамц	44	Аринболор	???	20.0		20.0
					А-гийн дүн		20.0		20.0
23	АН	23	Жанчивын Цэндсүрэн	45	Ганболд	???	500.0		500.0
				46	Түмэнхүү	???	500.0		500.0
				47	Сүхээ	???	300.0		300.0
				48	Б.Нандинсоёл	???	300.0		300.0
					А-гийн дүн		1,600.0		1,600.0
24	МАНХН	23	Тогоохүүгийн Хүрэлбаатар	49	Ц.Оюунсайхан	???	700.0		700.0
					А-гийн дүн		700.0		700.0
25	АН	29	Жамбалийн Батцэнгэл	50	Б.Баатарчулуун	???	2,000.0		2,000.0
					А-гийн дүн		2,000.0		2,000.0
26	МАНХН	26	Баасанжавын Оролзод	51	Энхцог	???	100.0		100.0

				52	Идэрзаяа	???	150.0		150.0
				53	Цэрэнжаргал	???	200.0		200.0
				54	Батсайхан	???	670.0		670.0
					А-гийн дүн		1,120.0		1,120.0
27	МА ХН	5	Чадраабалын Бадамхатан	55	???	???	500.0		500.0
					А-гийн дүн		500.0		500.0
28	МА Н	13	Цэрэндагвын Гүнбаатар	56	Ц.Дамба	???	1,000.0		1,000.0
				57	Б.Цэнд-Аюуш	???	1,000.0		1,000.0
				58	Н.Дэнсмаа	???	1,000.0		1,000.0
					А-гийн дүн		3,000.0		3,000.0
29	АН	25	Эрдэнийн Болормаа	59	Жигмэддорж	???	1.0		1.0
					А-гийн дүн		1.0		1.0
30	МА ХН	15	Энэбишийн Азбилэг	60	О.Буяннэмэх	???	500.0		500.0
					А-гийн дүн		500.0		500.0
31	МА Н	6	Цэвэг- Очирын Эрдэнэбаатар	61	Б.Халзан	???	500.0		500.0
					А-гийн дүн		500.0		500.0
32	МА Н	17	Болдбаатары н Нямдорж	62	Н.Энхболд	???	1,000.0		1,000.0
					А-гийн дүн		1,000.0		1,000.0
33	МА Н	17	Миеэсүрэнги йн Энхтайван	63	Н.Энхболд	???	1,000.0		1,000.0
					А-гийн дүн		1,000.0		1,000.0
			НИЙТ ДҮН		А-гийн дүн		28760. 0	182. 0	28942. 0